



**МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 1282

Мандалговь

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.2, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх "Цагаандэлгэр сумын ЗДТГ-ын албан хэрэгцээнд суудлын авто машин" нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: О.Бархүү (Дундговь-Ус орон нутгийн өмчтэй үйлдвэрийн газрын захирал)

Гишүүд: Г.Мандах (Аймгийн Засаг даргын туслах)

Б.Оргилболд (Их газрын чулуу байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны нягтлан бодогч)

Н.Мэндсайхан (Иргэний төлөөлөл)

Нарийн бичиг: Б.Сайхантуяа (Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2. Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (О.Бархүү)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Сайхантуяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МОНХБАТ



482210050*